# УЛААНБААТАР хотын Ардын Депутатуудын хурлын Гүйцэтгэх Захиргааны ТОГТООЛ

1969 оны 10-р сарын 9-ны өдөр Дугаар 338 Улаанбаатар хот

ГЗ-ын 1990 оны 140-р тогтоолоор хүчингүй

## ХОТЫН ТЭЭВРИЙН ЗАРИМ АВТО БАЗУУДЫН ХАРЬЯАЛЛЫГ ТОГТООХ ТУХАЙ.

Улаанбаатар хотын АДХ-ын Гүйцэтгэх Захиргаанаас ТОГТООХ нь:

1.Улаанбаатар хотын Авто тээврийн дор дурьдсан базуудыг 10-р сарын 25-наас эхлэн Хотын Тээвэрийг удирдах газарт харьяалуулсугай.ҮҮНД:

-Хотын Худалдаа удирдах газрын тээвэр түлш, хангамжийн нэгдсэн баз.

-Хот нийтийн аж ахуйн авто баз.

-Гадаадын мэргэжилтнийг үйлчлэх газрын авто баз.

-Автобус баз.

-Такси баз.

2.Хотын Тээврийг удирдах газарт дээр дурьдсан авто базуудыг бүх хүн хүч, машина механизм, сэлбэг хэрэгслэл, техник тоног төхөөремж, үндсэн хөрөнгө, материалын хамтаар 10-р сарын 25-ны дотор балансаар шилжүүлэхийг хотын Худалдаа удирдах газар /н.ДАМДИНСҮРЭН/, хот нийтийн аж ахуйг удирдах газар /н.ШАРАВЛАМДАН/, Гадаадын мэргэжилтнийг үйлчлэх газар /н.ЯДАМСҮРЭН/ нарт даалгасугай.

3.Хотын тээврийн эдгээр авто аж ахуйнуудыг цаашид төрөлжүүлэх болон үйлчилгээний газруудын Түлш хангамжийн аж ахуйг зохион байгуулах тухай саналаа боловсруулж 10-р сард Гүйцэтгэх захиргаанд оруулахыг хотын Тээвэрийн удирдах газар / /н.БҮРНЭЭ/-т даалгасугай.

4.Улаанбаатар хотын дэвсгэрт орших байгаа авто аж ахуйнуудын тээврийн хэрэгслэлийн ашиглалтанд байнгын хяналт тавьж тодорхой удирдлагаар хангаж ажиллахыг Тээврийг удирдах газарын дарга /н.БҮРНЭЭ/-д хүрэг болгосугай.

УЛААНБААТАР ХОТЫН АДХ ЫН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРГААНЫ ДАРГА Д:ЦЭДЭВ

УЛААНБААТАР ХОТЫН АДХ ЫН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРГААНЫ ХАРИУЦЛАГАТАЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА Д.ДАМДИНСҮРЭН